

**"МОНГОЛ ШУУДАН" ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2023.04.25

№ ХТ-23/01

Улаанбаатар хот

Огноо: **2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр**

Цаг: **10:00-12:10**

Хурал болсон газар: **"Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ийн хурлын танхим**

Хурлын дарга: **Банзрагч Ганбаатар /ТУЗ-ийн хараат бус гишүүн/**

Хурлын нарын бичгийн дарга: **Д.Цэцгээ /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/**

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: **32**

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо: **95,533,843**

Хурлын ирц: **95.9%**

Хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай,
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлын төсөв батлах тухай,
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох тухай,

"Монгол шуудан" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 10:00 цагт "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ийн хурлын танхимд явагдлаа. Хуралд хурлын дарга Б.Ганбаатар, ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл, ердийн гишүүн Д.Дэлгэрмаа, Г.Тэлмэн, Б.Батцэцэг, О.Одбаяр, хараат бус гишүүн Д.Балдорж, Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар болон компанийн удирдлагын багийн бүрэлдэхүүн биечлэн оролцлоо.

Хурлын бүртгэлийг 10:00 цагт хааж, тооллогын комиссын дарга О.Сарангэрэл хурлын ирцийн мэдээллийг хурлын даргад мэдээлснээр хурал эхэллээ.

Хурлын дарга Б.Ганбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. "Монгол шуудан" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 03 сарын 15-ны өдрийн хурлаар Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн хурлыг хараат бус гишүүний төлөөллөөр удирдуулах санал гарч миний бие энэ удаагийн хурлын даргаар сонгогдсон. Хурлын тооллогын комиссын зүгээс хурлын ирцийн мэдээллийг танилцууллаа. Хурлын ирц 95.9 хувьтай байгаа тул хурлыг эхлүүлэе.

- Хурлын дарга Б.Ганбаатар хурлын дэгийг танилцууллаа.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1: Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

Хурлын дарга Б.Ганбаатар: Хурлын дэгийн дагуу Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулна.

- Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцууллаа.

Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар: Юуны өмнө Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаа хүрэлцэн ирсэн та бүхэнд эх орны өнцөг булан бүрд ажиллаж, амьдарч байгаа нийт шууданчдынхаа өмнөөс мэнд хүргэе. Компани нь 2022 онд цар тахлын дараах үеийн бизнесийн үйл ажиллагааг хэрхэн тасралтгүй авч явах, эдийн засгийн нөлөөллийг хэрхэн давж гарах талаар шийдвэрүүдийг гарган ажиллаа. Тэр дундаа улс орны нийгэм эдийн засгийн хүндрэл, валютын ханшийн өсөлт зэрэг олон хүчин зүйлүүдийг даван туулахад хүндрэлүүд үүсэж байсан ч гэсэн



“Монгол шуудан” ХК-ийн нийт ажилтан албан хаагчид бид бүхэн 2022 онд тавьсан зорилт, стратеги төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаа амжилттай хийж гүйцэтгэсэн. (Танилцуулгыг хавсаргав)

Хурлын дарга Б.Ганбаатар: Гүйцэтгэх захиралд баярлалаа. Хурлын дэгийн дагуу компанийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн аудитын дүгнэлтийг Аудитын хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Балдорж танилцуулна.

- Аудитын хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Балдорж компанийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн аудитын дүгнэлтийг танилцууллаа. (Танилцуулгыг хавсаргав)

Хурлын дарга Б.Ганбаатар: Аудитын хорооны дарга Б.Балдорж гишүүндээ баярлалаа. Одоо дэгийн дагуу компанийн 2021 оны ногдол ашиг тараасан тухай тайлан болон 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Батцэцэг танилцуулна.

- ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Батцэцэг компанийн 2021 оны ногдол ашиг тараасан тухай тайлан болон 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцууллаа. (Танилцуулгыг хавсаргав)

Хурлын дарга Б.Ганбаатар: Дараагийн асуудал болон ТУЗ-ийн 2022 оны тайланг ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл танилцуулна.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа хүрэлцэн ирсэн та бүхэндээ талархал илэрхийлье. Компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо 3 мянга давсан байна. Компани 2022 онд Улс хоорондын болон хил дамнасан и-худалдаа буюу транзит шуудангийн бизнесийг өргөжүүлэх чиглэлээр ТУЗ-тэй хамтран олон ажлууд хийсэн. Дотоод шуудангийн хувьд төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дотоод шуудангийн солилцоо багассан ч ковидын хол хориотой байх үеийн өсөлтийн хэмийг алдахгүй байх тал дээр анхаарч ажилласан. Мөн гүйцэтгэлд суурилсан цалин урамшууллын системд нэвтрүүлэхэд шаардлагатай цагийн бүртгэл, цалин, хүний нөөцийн системийг нэвтрүүлсэн. Ингэснээр нэлээд хүндрэлүүдтэй учирсан. Тогтмол цалин авдаг байсан шууданчид бүтээмж рүү чиглэсэн ажил руу ороход эсэргүүцэл илэрхийлсэн, санал гомдол гаргасан. ТУЗ-ийн зүгээс компани 2022 онд үйл ажиллагаагаа урт болон дунд хугацаанд өргөжүүлэх, тогтвортой байдлыг хангахад гол үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан байна гэсэн дүгнэлтийг өгч байна. Хөндлөнгийн аудитын байгууллагаас өөрчлөлтгүй дүгнэлт авсан. Иймд компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс компани нь 2022 онд “Сайн” ажилласан байна гэсэн дүгнэлтийг өгсөн байна. Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа. (Танилцуулгыг хавсаргав)

Хурлын дарга Б.Ганбаатар: Д.Нарангэрэл даргадаа баярлалаа. Хурлын дэгийн дагуу дараагийн хэлэлцэх асуудалдаа орёе.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 2: ТУЗ-ийн 2023 оны зардлын төсөв батлах тухай;

Хурлын дарга Б.Ганбаатар: ТУЗ-ийн 2022 оны зардлын гүйцэтгэл, 2023 оны зардлын төсвийг ТУЗ-ийн гишүүн Г.Тэлмэн танилцуулна.

- ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүн ТУЗ-ийн ердийн гишүүн Г.Тэлмэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлын төсвийг танилцууллаа. (Танилцуулгыг хавсаргав)

ТУЗ-ийн гишүүн Г.Тэлмэн: Хувьцаа эзэмшигчдэдээ энэ өдрийн мэнд хүргэе. Бид сая эхний асуудлыг хэлэлцэж дууслаа. Хурлын даргын зүгээс хэлэлцэх асуудал болгоны дараа асуулт, хариултын цагыг заавал бий болгох ёстой. Хувьцаа эзэмшигчид маань өөрсдийн тодруулах

шаардлагатай зүйлүүд дээрээ асуултаа асуугаад, хариултаа аваад явсан нь зүйтэй болов уу гэж бодож байна. Миний хувьд 8 дах жилдээ "Монгол шуудан" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байна. Анх олон нийтийн компани болоход нь хараат бус гишүүнд нэр дэвшиж байсан. Түүнээс хойш компанид орж ажилласан. Мөн одоо ТУЗ-ийн ердийн гишүүнээр ажиллаж байна. ТУЗ нь 2022 онд үндсэн болон нэмэгдэл зардал бүхий 6 бүлэг зардлыг баталсан. Компанийн хувьд дан ганц дотоод бизнес биш, олон улсын бизнес буюу тэр дундаа транзит шуудангийн бизнесийг өргөжүүлээд явах нь зүйтэй байдаг. 2020, 2021 онд ковидын нөхцөл байдлаас шалтгаалаад гадаад томилолт хийж чадаагүй. Томилолтын зардлын хувьд ТУЗ-ийн төлөөлөл болж миний бие 2022 онд 2 удаагийн гадаад айлчлалд оролцсон. Эхний томилолт бол 2022 оны 3 сард Оросын шуудангийн байгууллагатай Улан-Үдэ хотноо хэлэлцээр хийснээр транзит шуудангийн шимтгэлийн орлогыг 40 хувь нэмэгдүүлж чадсан. 2 дах томилолт нь 2022 оны 5 сард Дэлхийн шуудан холбооны байгууллагын хуралд оролцож шуудангийн хөгжлийн цаашдын чиг хандлага, олон улс руу чиглэсэн бизнесийг ярилцсан. Цаашдаа миний хувьд гадаад үйл ажиллагаа руу чиглэсэн ажилд сайн оролцох ёстой гэж боддог. Шуудангийн үйл ажиллагааны орлогын 3/1 хувийг гадаад үйл ажиллагааны орлого эзэлж байна. Өнгөрсөн жилийн ашигт ажиллагаа 100 хувь гадаад бизнесээс орж ирсэн. Иймээс энэ нь ямар ач холбогдолтой зүйл вэ гэдгийг та бүхэн ойлгож байгаа байх. ТУЗ-ийн цалингийн хувьд өнгөрсөн жилүүдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдөх үеүдэд бага хэмжээгээр өөрчлөлт орж явсан. ТУЗ-ийн зүгээс 2023 онд цалингийн хувьд тодорхой өөрчлөлт оруулах нь зүйтэй гэсэн саналтай орж ирж байгаа. ТУЗ-ийн хариуцлага, үүрэг нь шинэ батлагдсан хууль болон засаг, төрөөс барьж байгаа бодлогын хүрээнд нэмэгдэж байгаа. Мөн инфляцын түвшинтэй нийцүүлээд тодорхой хэмжээгээр өөрчлөлт орох нь зүйтэй гэж бид үзсэн. Өнөөдрийн хурлаар ТУЗ-ийн даргыг 1.5, хороодын дарга нарыг 1.4, бусад гишүүдийг 1.3, нарийн бичгийн даргыг 1.3 саяын цалинтай болгохоор зардлын төсөвт тусгасан. ТУЗ-ийн гишүүдийн хувьд компанийн ашигт ажиллагаа их, бага байснаас үл шалтгаалаад нэмэлт урамшуулал авдаггүй. Цаашдаа тогтмол цалин болон компанийн ашигт ажиллагаатай уялдуулж урамшуулалтай болгох саналуудыг оруулж ирнэ гэсэн бодлоготой байна. Нөгөө талаасаа Компанийн тухай хуулиар явъя гэхээр 66 хувийг төр эзэмшдэг учраас төрөөс тавьж байгаа хязгаарлалтууд нөлөөлдөг. Гэхдээ 1009 хүний аж амьдралыг авч яваа, дэлхийн 192 улстай харилцаатай байдаг компанийн хувьд ТУЗ-ийн гишүүдийн үүрэг хариуцлага өндөр байх ёстой. Эргээд үүнтэйгээ дүйцэхүйц цалин, урамшуулал өндөр байх ёстой гэж үздэг. ТУЗ-ийн 2023 оны зардлын төсвийн хувьд ТУЗ-ийн цалингийн нэмэгдлийг оруулаад 198 сая төгрөгөөр төлөвлөн оруулж ирж байна. Миний танилцуулсан асуудалтай холбоотойгоор асуулт байвал хариулахад бэлэн байна.

Хурлын дарга Б.Ганбаатар: Г.Тэлмэн гишүүндээ баярлалаа.

Асуулт, хариулт:

Хувьцаа эзэмшигч Жавхлан: Сайн байцгаана уу. Намайг Жавхлан гэдэг. Би хувьцаа эзэмшигч өөрийн төрсөн охин Энхрийлэнгийн хууль ёсны төлөөлөгч. Хуралд оролцох гээд ирсэн боловч 10 минут хоцорчихсон. Үүдэнд бүртгэл хийж байгаа тооллогын комиссын ажилтнууд хурлын ирцийн бүртгэл дуусаад мэдээлэгдсэн тул саналын хуудас өгөхгүй гэсэн. Ямар дүрэм журмаар санал өгөх эрхгүй болж байгаа вэ. Хэрэв дүрэм журам зөрчөөгүй байх юм бол саналын хуудсаа аваад саналаа өгье гэж бодож байна. 2-рт: Хувьцааны арилжаа дээр энгийн хувьцаа эзэмшигч нар илүү анхаарал хандуулдаг. Нийт хөрөнгөөс өр төлбөрийг хасаад эздийн өмчийг нийт гаргасан хувьцаандаа хуваахаар хувьцааны бодит үнэ гарч ирж байгаа. Энэ харьцаа одоо зах зээл дээр борлогдож байгаа хувьцааны ханш 2-ын зөрүү байгаа юу. Энэ нь олон улсын жишгээр байж болох ханш дээрээ явж байгаа юу. 3-рт: Саяхан манай эхнэр Герман руу шуудан явуулах болоод DHL хамгийн хурдан байдаг гээд тэнд өгсөн. Миний тооцооллоор "Монгол шуудан" ХК-ийн зардлаас 100 гаран мянган төгрөгийн илүү зардлаар DHL-ээр явуулсан. "Монгол шуудан" ХК-иас асуухаар яг ижил нэг онгоцоор Герман руу материал явсан болж таарч байна. Эндээс "Монгол шуудан" ХК нь DHL-ээс хурдтай яваад байгаа юм уу, эсвэл яг нэг ижил хугацаанд очиж байна уу. Эсвэл нь DHL илүү маркетинг сайн байгаа юм уу гээд энэ тал дээр "Монгол шуудан" ХК хэрхэн ажиллаж байгаа бол. Би хувьцаа эзэмшигчдийн хурлаас өмнө МИУС дээр судалгааны ажил харлаа. 2010 онд нийтдээ инновацийн удирдлага сэдвээр Монгол шуудангийн

жишээ дээр ганцхан судалгааны ажил байсан. Монгол шуудангаас доктор, профессор хамгаалахаар судалгааны ажил хийж байгаа залуучууд байна уу. Өмнө нь судлагдаж байсан ажлуудаа хэрэгжүүлдэг үү. Миний үзсэн судалгааны ажил дээрээс ойлгоход түүхэн үеэсээ авхуулаад морьт шуудан гээд явуулдаг байсан юм байна. Шуудангийн үйлчилгээ бол номер нэг дэлхийд үндэслэгч гэж болохоор түүхтэй юм байна. Үүнтэйгээ холбогдуулан багахан хэмжээний ч гэсэн маркетинг, сурталчилгааг хийж ажиллах бодол байгаа юу.

Хурлын дарга Б.Ганбаатар: Баярлалаа. Хуралд санал өгөх асуудал, хувьцааны ханш, олон улсын шуудангийн зардал, сурталчилгааны талаар гээд 3 асуудал хөндлөө. Сүүлийн 2 асуултад гүйцэтгэх захирал хариу өгье.

Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар: DHL компанийн хувьд олон улсын буухиа шуудангийн үйлчилгээ үзүүлдэг компани. "Монгол шуудан" ХК-ийн хувьд Дэлхийн шуудан холбооноос гаргасан EMS буюу экспресс шуудангийн үйлчилгээг олон нийтэд сурталчлах ажил дээр анхаарч ажилладаг. Хугацааны хувьд DHL компанитай нэг хугацаанд очиж байгаа. Үнэ тарифын хувьд 30-40 хувь хямд. Хэрэглэгчдэд илүү сонголттой байлгахын тулд DHL компанийн хажууд EMS буюу экспресс шуудангийн үйлчилгээ үзүүлэх шуудангийн салбарыг байгуулсан. Үйлчилгээний чанарын хувьд тогтсон ажлын 3-5 хоногт гэдэг хугацаагаар үйлчилгээ үзүүлж байна. Сурталчилгаа тал дээр бид илүү анхаарч ажиллах ёстой гэж үзэж байна. Шуудантай холбоотой, судалгаа, хийгдсэн ажлууд гэж ярьсан. Мэдээлэл, холбооны технологийн сургууль дээр мэргэжлийн шуудангийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг анги байсан. Гэвч 2017 оноос хойш энэ мэргэжлийн анги элсэлт аваагүй. Бид шуудангийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг ангийг дахин нээж өгөөч гэсэн санал хүсэлтээ Мэдээлэл, холбооны технологийн сургуульд тавьж байгаа. Компанийн хувьд мэргэжлийн чиглэлээр ажилдаг боловсон хүчин хомс байна гэдгээ илэрхийлсэн. Компанийн хувьд шуудангийн талаар судалгаа шинжилгээ хийж байгаа оюутнуудтай хамтран ажиллахад нээлттэй байна.

Хурлын тооллогын комиссын гишүүн Г.Долгорсүрэн: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тооллогын комиссын хувьд үнэт цаас гаргагчдын хувьцаа эзэмшигчдийн хурал хийх Санхүүгийн зохицуулах хорооны журам байдаг. Энэ журмын дагуу урьдчилан санал авах хугацаа, цаг болон хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэл хийх, эхлүүлэх цаг хугацаануудыг хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай тогтоолоор баталж, олон нийтэд зарласан байдаг. Өнөөдрийн хувьд "Монгол шуудан" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн бүртгэл 09:30-10:00 цагийн хооронд хийгдэж, 10:00 цагт хурлын ирцийн мэдээллийг тооллогын комиссын тогтоолоор баталж, хурлын даргад мэдээлэн хурлыг эхлүүлсэн тул энэ хугацаанаас хойш ирсэн хувьцаа эзэмшигч санал өгөх эрхгүй байгаа.

Хувьцаа эзэмшигч Ч.Амарбаатар: "Монгол шуудан" ХК буюу шуудан оршин тогтнож байгаад баяртай байна. Хажууд нь DHL гэдэг супер компаниуд маш өндөр ашигтай ажиллаж байна. Тэгэхээр бидэнд ирээдүй байна гэж харж байна. Миний хувьд энэ асуудлаас илүү санаа зовж байгаа зүйл нь Оросын хориг байна. Энэ хориг бидэнд асар их боломжийг гаргаж өгч байна гэж харж байна. Монгол улс 2 том гүрний дунд байж байдаг. Бид энэ Оросын хориг дээр сайн ажиллах хэрэгтэй байна. Энэ нь Монгол улсын хувьд асар их боломж гэж харж байна. "Монгол шуудан" ХК-ийн хувьд энэ боломж дээр ажиллаж байгаад баяртай байна. Гэхдээ ханшийн зөрүү гэдэг жижиг зүйлээс хэдэн төгрөг босгох гэдэг нь эрсдэлтэй зүйл. Ханш буугаад ирвэл алдагдалд орох маш эмзэг асуудал. Мөн Хөшигийн хөдийд баригдаж байгаа төв хэзээ ашиглалтад орох вэ. Өнгөрсөн жилийн 11 сард очиж үзэхэд барилга дутуу байсан. Санхүүжилтийг шийдээд өгчихвөл барилгын ажил дуусах гээд байна гэсэн тайлбарыг барилгын компани ярьж байсан. Хувийн хэвшлийн байгууллагууд маш хурдтай шийдвэр гаргаад явчихдаг. Төрийн өмч давамгайлсан компанийн хувьд шийдвэр гаргах гээд уддаг. Бид төр шийдвэр гаргахыг хүлээгээд суугаад байхгүйгээр компанийн ТУЗ хурдтай ажиллах санал тавьж байна. Шаардлагатай тохиолдолд заавал цугларч байж шийдвэр гаргахгүйгээр цахимаар хуралдаад шийдвэр гаргах боломж байна. Хүнд суртал гаргалгүйгээр хурдтай шийдвэрүүдийг гаргаж амжилттай ажиллахыг ерөөе. Удирдлагын багийг сайн гэж дүгнэсэн байна. Би шинээр орж ирсэн хувьцаа эзэмшигч болохоор ямар байсныг сайн мэдэхгүй болохоор дүгнэлтийг хэлж чадахгүй байна. Тайлангаас харахад 20

гаран тэрбум төгрөгийн гүйлгээ хийчхээд 400 саяын ашиг гэхээр хангалтгүй санагдаж байна. Энэ жил гүйцэтгэх удирдлага аль болох бүтээмж тал руугаа илүү анхаарал тавиад ажиллаарай.

Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар: Барилгын ажлын хувьд 97 хувийн гүйцэтгэлтэй байна. Өнгөрсөн хугацааны барилгын үнийн өсөлт, хил гаальтай холбоотойгоор гүйцэтгэгч компанийн зүгээс тодорхой хэмжээний өсөлт үүссэн учир нэмэлт санхүүжилт шийдэж өгөөч гэсэн хүсэлтийг тавьсан. Бид бүхэн Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төв гээд холбогдох байгууллагуудад хандсан. Барилгын хөгжлийн төвөөр гүйцэтгэлд нь хяналт тавиулаад ТУЗ-д танилцуулсан байгаа. Энэ 7 хоногтоо амжвал ТУЗ-ийн дэргэдэх Стратеги, эрсдэлийн удирдлагын болон Аудитын хороогоор оруулаад, дүгнэлт гаргуулан ТУЗ-өөр хэлэлцэн санхүүжилт олгох асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Гүйцэтгэгч компанийн зүгээс нэмэлт санхүүжилт шийдэгдчихвэл нэг сарын хугацаанд ажлаа гүйцэтгээд Улсын комисст хүлээлгэж өгнө гэсэн. Бид 7 сарын 01 гэхэд үйл ажиллагаагаа эхлүүлэхээр төлөвлөсөн. Мөн гаалийн хяналтын бүсээр зарлуулах ёстой тул цаг алдахгүйн тулд давхар хүсэлтүүдээ өгөөд явж байна.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Ковидын үед барилгын бараа материалын үнэ их өссөн. Барилгын 800 гаруй нэр төрлийн материал дотроос нэрсийг нь гаргаад УИХ-ын тогтоол батлаад, энэ бараа материалуудын үнэ өссөн юм байна гэж гаргаж ирсэн. Энэ тогтоол батлагдсантай хологдуулаад магадлан хийлгээд, энэ барилгын барихад тэдэн төрлийн бараа материал орсон байна. Хүлээн зөвшөөрөгдөх жагсаалтаас харж байгаад энэ энэ материалын үнийн өсөлтийг зөвшөөрөх юм байна. Энэ энэ материал эх орны үйлдвэрээс авах боломжтой юм байна гэх мэтээр нарийн төвөгтэй процесс явж байгаа. Үүнийг зөвхөн төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа барилга байгууламж дээр гаргаад явчихсан. Компанийн хөрөнгөөр, хувьцаа эзэмшигчдийн татан төвлөрүүлсэн хөрөнгөөр хийгдэж байгаа жил дээр энэ өсөлтийг хүлээн зөвшөөрөх үү, үгүй юу гэдэг асуудлыг бид аль аль шатандаа зөвшөөрүүлэх гэж нэлээд их явсан. Бид Барилга, хот байгуулалтын яаманд нөхцөл байдлаа ярьж байгаад энэ үнийн өсөлтийг төсвийн байгууллагууд дээр биш компанийн мөнгөөр хийгдэж байгаа барилга байгууламжийн ажил дээр зөвшөөрөл олгооч гэсэн албан бичгийг өгсөн боловч өнөөдрийн байдлаар зөвшөөрөл өгөөгүй байна. Гэвч ТУЗ-ийн зүгээс бид энэ үнийн өсөлтийг шийдвэрлэхгүй бол болохгүй юм байна гэдэг дүгнэлтэд хүрсэн байгаа. Иймээс ТУЗ-ийн дэргэдэх 2 хороог хуралдуулж, үнийн өсөлтийг хүлээн зөвшөөрөх эсэх талд дээр дүгнэлт гарсны дараа ТУЗ-өөр хэлэлцэн шийдвэр гаргахаар ярилцсан байгаа. Барилга, хот байгуулалтын яамнаас зөвшөөрөл авах гэж цаг хугацаа алдсан тал байгаа. Ч.Амарбаатар хувьцаа эзэмшигчийн хэлсэн саналыг ойлголоо. Хурдан шуурхай шийдвэр гаргаад энэ ондоо төвөө ашиглалтад оруулах арга хэмжээ авна.

Хурлын дарга Б.Ганбаатар: ТУЗ-д хандан түргэн шуурхай шийдвэр гаргаж ажиллана уу гэж санал хэллээ. Өнөөдөр шинээр сонгогдох ТУЗ-ийн гишүүд анхаарал хандуулж ажиллана гэд найдаж байна. Өөр санал, хүсэлт, асуулт байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалд орёё.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 3: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай;

- Засаглал нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны дарга Д.Дэлгэрмаа "Монгол шуудан" ХК-ийн ТУЗ-д нэр дэвшигчдийг танилцууллаа.

ЗНДЦУХ-ны дарга Д.Дэлгэрмаа: "Монгол шуудан" ХК-ийн ТУЗ нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй. 6 нь ердийн, 3 нь хараат бус гишүүн байдаг. 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 2 жилийн хугацаатайгаар кумулятив аргаар сонгосон байгаа. Гэвч тайлант хугацаанд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон учраас кумулятив аргаар дахин бүрэн бүрэлдэхүүнээр нь нэр дэвшүүлж сонгон шалгаруулах шаардлагатай болсон. (Танилцуулгыг хавсаргав)

Хурлын дарга Б.Ганбаатар: Д.Дэлгэрмаа гишүүнд баярлалаа. Нэр дэвшигчдээс асуух асуулт байхгүй бол санал хураалтыг явуулъя. Тооллогын комисс саналын хуудсыг нэгтгэж дуусгаад, санал хураалтын дүнг танилцуулах тул 20 минутын завсарлага авъя.

- Тооллогын комиссын гишүүд саналын хуудас бөглөх зааврыг хувьцаа эзэмшигчдэд танилцууллаа.

Хурлын завсарлага 12:00 цагт дуусаж, хуралдаан үргэлжиллээ.

Хурлын дарга Б.Ганбаатар: Одоо тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулна

- Тооллогын комиссын дарга О.Сарангэрэл санал хураалтын дүнг танилцууллаа.

Хурлын дарга Б.Ганбаатар: Санал хураалтын дүнтэй танилцлаа. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор "Монгол шуудан" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолыг танилцуулъя.

- Хурлын дарга Б.Ганбаатар "Монгол шуудан" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан тогтоолыг танилцууллаа.

Хурлын дарга Б.Ганбаатар: Хурлын үйл ажиллагаа батлагдсан дэгийн дагуу амжилттай болж дууслаа. Хуралдаа идэвхтэй оролцсон хувьцаа эзэмшигч та бүхэндээ баярлалаа. Мөн шинээр сонгогдсон ердийн болон хараат бус гишүүд сайн ажиллаж, өмнөх жилүүдийн ололт амжилтаа дээшлүүлж, удирдлагаар хангаж ажиллахыг хүсье. Та бүхэнд эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе. Хурал хаасныг мэдэгдье. Та бүхэнд баярлалаа.

Энэ удаагийн хурал 12:10 цагт өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА:



Б.ГАНБААТАР

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Д.ЦЭЦГЭЭ